

  
 БАТЛАВ:  
 ДОРНОДАЙМГИЙН ЗАСАГ  
 ДАРГА *О* М.БАДАМСҮРЭН

**ТҮЙМЭРТ ШАТСАН ХӨНӨӨЛТ ШАВЖИД НЭРВЭГДСЭН, МОД  
БЭЛТГЭСЭН 50 ГА ТАЛБАЙД ОЙЖУУЛАЛТ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР**

Хэрлэн сум

Ажил гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгуулла гыг сонгон шалгаруу- лахад харгалзах үзүүлэлт	<b>Ажлын шалгуур</b>
	Оролцох аж ахуйн нэгж, байгууллага: Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олгосон “Мод үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээх” ойн мэргэжлийн байгууллагын эрхтэй, тарьц суулгацын нөөцтэй, ажлын туршлагатай орон нутгийн аж ахуйн нэгж.
	1. Ойн инженер 2. Ойн техникч 3. Ойжуулагч зэрэг мэргэжлийн боловсон хүчин байна. Ажлын туршлага: Өмнө жилүүдэд хийсэн ойжуулалтын ажил болон адил төстэй бусад ажлын акт, тодорхойлолт, гэрээний хувийг хавсаргана.
	Стандартын шаардлага хангасан шилмүүст модны тарьц, суулгацын нөөцтэй байна. /MNS:6140-2010 стандарт хангасан байх, нэг га талбайд чанарын 1 дүгээр зэргийн шилмүүст төрлийн модны нөөц бүрдүүлсэн байх/
	Ойжуулалтын ажил хийх болон таримал ойг цаашид арчлах, хамгаалах талаар захирал болон ерөнхий инженерийн баталгаажуулсан технологийн карттай байна.
	Тоног төхөөрөмж: Мод тарих колесовын царил, жоотуу, хүрз, усалгааны емкость, хувин, усалгааны хоолой зэрэг багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмжтэй байна. /техник тоног төхөөрөмжийн зураг бусад нотлох баримтаар баталгаажуулсан байх/
Бэлтгэл ажил	Ойжуулах ажлын технологийн картыг сум дундын ойн ангиар хянуулж, ойжуулалтад гаргасан тарьц, суулгацыг 3 жилийн хугацаанд арчлан ургуулах, нөхөн тарих төлөвлөгөөг сум дундын ойн ангиар батлуулсан байна.
	Ойжуулах талбайг өөрийн хөрөнгөөр цэвэрлэж бэлтгэн, хашиж малын хөлөөс хамгаалах ажил хийгдсэн байна. Сум дундын ойн ангиар талбайг тусгаарлуулсан байх, өнцгүүдэд шон босгож, талбайд шан татаж, чиг тэмдэг тавьсан байна.
	Тарьц суулгацыг ачих буулгах, түр хадгалах технологи, горим мөрдсөн байна.
Үе шатууд	Ойжуулалтын ажил нь бэлтгэл, ойжуулах, ойжуулсан талбайг хүлээлгэн өгөх, зөрчил, гологдол арилгах, тайлан боловсруулах, тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх, дараагийн жилийн арчилгаа хамгаалалт хийх гэсэн үе шатуудтай байна.
Байршил	Баян-Уул сумын “Ар Дархинт гэх газарт нарс /тарьц/ модоор 50 га талбайд ойжуулалтын ажил гүйцэтгэх.
Үндсэн	Талбайн хөрсийг боловсруулж мод тарих технологи мөрдөж тарьцыг 30 см гүнд тарилт хийх;
	Ойжуулалтын ажил гүйцэтгэхдээ мод хооронд 1, эгнээ хооронд 4 метр зайтай, 1 га талбайд 2500 ширхгээс доошгүй байхаар тооцож

*4/10.*

ажил	тарилт хийх;
	Технологийн картын дагуу тарьцыг усалж, арчлан хамгаалах ажлыг хийж гүйцэтгэх;
	Хөрсний чийг тохиромжтой хувиас доогуур тохиолдолд усалгааг хийх;
	Ойн ангийн инженер, байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагчаас арга зүйн заавар зөвлөгөө авч ажиллах;
	Ойжуулалтын ажил хүлээлгэж өгснөөс хойш 3 жилийн хугацаанд гүйцэтгэгч аж ахуйн нэгж ургах чадваргүй болсон тарьц, суулгацыг авч нөхөн тарилт хийж, арчлан хамгаалах арга хэмжээ авсан байх;
	Багц тус бүр ойжуулсан талбайд мал бэлчээхийг хориглосон анхааруулга пайз 4, ажлын танилцуулга бүхий 2x2 м хэмжээтэй төмөр самбар 1 ширхэгийг байрлуулна.
	Тарьсан ойг тойруулан хүний сөрөг нөлөө, мал амьтны хөлөөс хамгаалах арга хэмжээ авч, мөн гал түймрээс хамгаалах 10м өргөнтэй шороон зурвас татна.
Үр дүн	Ойжуулалтын ажлын хувийн хэргийг хөтлөн, талбайн ажлын үе шат бүрийг фото зураг, бичлэг хийж гүйцэтгэлийн хамт ажлын хэсэгт танилцуулсны дараа акт үйлдэнэ.
	Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг актаар хүлээлгэн өгнө.

ХЯНАСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА *[Signature]* М.НЯМСҮРЭН

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН *[Signature]* С.СОЛОНГО

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН *[Signature]* Э.МӨНХЧИМЭГ

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУДЧЛАЛЫН  
ГАЗРЫН ДАРГА *[Signature]* А.ГАНТУЛГА